

ОРОН СУУЦ НИЙТИЙН АЖ АХУЙН УДИРДАХ ГАЗАР ОНӨААТҮГ

**БАГАЖ ХЭРЭГСЭЛ НИЙЛҮҮЛЭХ
ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ
БИЧИГ**

Төслийн нэр: **Багаж хэрэгсэл нийлүүлэх**

Төслийн дугаар: **ОСНААУГ-БМ-19/23**

Улаанбаатар
2019 он

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар ОНӨААТУГ нь эрх бүхий тендерт оролцогчдоос **Багаж хэрэгсэл нийлүүлэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.**

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 30,000 /гучин мянган/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстай.

Үнийн саналыг **2019 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 10 цаг 30 минутаас өмнө** цахим системд ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2019 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 11 цаг 00 минутад** нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй, эрхгүй эсэх: **Эрхгүй**
Дотоодын давуу эрх тооцох эсэх: **Тооцохгүй**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 6 дугаар хороо, Бумцэндийн гудамж, Их тойруу.

Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар

Утас: 70111722

Цахим хаяг: www.tender.gov.mn

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- | | |
|---|---|
| 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа | 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна. |
| 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт | 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ. |
| 3. Тендерийн иж бүрдэл | 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
(а) Үнийн санал;
(б) Үнийн бол нийлүүлэлтийн хуваарь;
(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
(д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.] |
| 4. Тогтмол үнэ | 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохиуулгын нөхцөлтэйгөөр ирсэн үнийн саналаас татгалзана. |
| 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд | 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ. |

- 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
- 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байна.

- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарыт заасан бараа нь **TШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТОӨЗ-НЫХОЛБОГОХ ЗААЛТ	Шалгуур үзүүлэлт
ТОӨЗ 1.1	<p>1. Унийн саналыг маягтын дагуу бэлтгэж, баталгаажуулан ирүүлнэ.</p> <p>2. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар /нотариатаар баталгаажуулан ирүүлэх/</p> <p>3. Компанийн дэлгэрэнгүй танилцуулга</p> <p>4. Сүүлийн нэг /2018 он/ жилийн аудитлагдсан санхүүгийн тайлан, дүгнэлтийн хамт ирүүлэх</p> <p>5. Ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл: /2017, 2018 оны аль нэг жилд гэрээгээр нийлүүлсэн барааны гэрээний хуулбар, гэрээ дүгнэсэн протокол, актны хуулбар ирүүлэх/</p> <p>6. Бараа нийлүүлэлтийн хугацаа</p> <p>7. Татварын тодорхойлолт ирүүлнэ. /Монгол Улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн байна. Татварын тодорхойлолтыг Татварын ерөнхий газрын www.etax.mta.mn сайтыг ашиглан цахим тодорхойлолт авч ирүүлэх ба энэхүү тодорхойлолт нь тендер нээсэн өдрийн байдлаар хүчинтэй байна. Мөн татварын байгууллагаас тодорхойлолт хүсэхэд татгалзах зүйлгүй тухай болон тендер шалгаруулалт зохион байгуулах журмын дагуу татвар төлөлт, Сангийн яамны санхүүгийн тайлангийн сангаас санхүүгийн тайлангийн талаарх шаардлагатай мэдээллийг тендер нээсэн өдрийн байдлаар шалгахад татгалзах зүйлгүй тухай мэдэгдлийг албан бичгээр ирүүлнэ.</p> <p>8. “Хугацаа хэтэрсэн зээл болон зээлийн хүүгийн төлбөрийн үлдэгдэлгүй” тухай харилцагч банкны тодорхойлолтыг эх хувиар ирүүлнэ.</p> <p>9. Санал болгож буй барааг санал болгосон үнээрээ хугацаандаа нийлүүлэхийг баталсан албан бичиг ирүүлнэ.</p> <p>10. Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт</p> <p>11. НӨАТ төлөгч байх бөгөөд гэрчилгээний хуулбар</p> <p>12. Баталгаат хугацаа 1 жил эсхүл түүнээс дээш жил байна. /Баталсан албан бичиг ирүүлнэ/</p> <p>13. Нийлүүлэх барааны дэлгэрэнгүй танилцуулгыг ирүүлнэ. /зураг, техникийн тодорхойлолтод байгаа үзүүлэлтийг санал болгож байгаа барааны үзүүлэлттэй харьцуулан ирүүлэх/</p> <p>14. ТШӨХ-д заасан материалыудын аль нэгийг тендерт хавсарган ирүүлэгүй бол тухайн тендерээс татгалзах үндэслэл болно.</p> <p>Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд: Шаардлагагүй</p>
ТОӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 6-р хороо, Бумцэндийн гудамж, Их тойруу, Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар</p> <p>Цахим хаяг: www.tender.gov.mn</p> <p>Огноо: 2019 оны 08 дугаар сарын 30-ны өдөр</p> <p>Цаг: 10 цаг 30 минут</p>

ТОӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: <i>Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 6-р хороо, Бумцэндийн гудамж, Их тойруу, Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар</i></p> <p>Цахим хаяг: www.tender.gov.mn</p> <p>Огноо: <i>2019 оны 08 дугаар сарын 30-ны өдөр</i></p> <p>Цаг: <i>11 цаг 00 минут</i></p>
ТОӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <i>багцгүй</i></p>

Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. Барааны тодорхойлолт:

Нийлүүлж байгаа багаж хэрэгслийг дараах шаардлагыг хангасан байна.

- Том, жижиг бахь, кусочиг, нугасан хошуутай бахь нь ган төмөр хийцтэй, бариул нь хамгаалалттай байна.
- Том отверканы багажны бүрдэл нь толгой сольдог байх.
- Жижиг отверканы багажны бүрдэл нь олон төрлийн толгойтой, торцовтой байх.
- Тусгай түлхүүрийн баганы бүрдэл нь НХ: 1,5-10мм, ТХ: 8-40 мм хэмжээтэй байх,
- Түлхүүрний багажны бүрдэл нь ган төмөрөөр хийгдсэн хагас болон бүтэн тойрог ажлын хэсэгтэй байх, 6-19 хүртэл хэмжээтэй
- Цахилгааны тестер нь хувьсах, тогтмол хүчдэл, гүйдэл хэмждэг байх
- Сүлжээний тестер нь RJ45, RJ10, RJ11 төрлийн толгойны оролттой, кабелын 2 талыг тодорхойлох дуут сигналтай байх.
- Сүлжээний бахь нь RJ45, RJ10, RJ11 төрлийн толгой залгадаг байх.
- Индикатор нь хувьсах болон тогтмол гүйдлыг шалгадаг байх
- Жижиг гар дрилл нь ажлын хэсгийг гэрэлтүүлдэг LED гэрэлтэй, цэнэг хянах боломжтой, уян болон 900 хошуутай, цэнэгээ хураадаг Литиниум /Lithium ion/ батерей, зөөвөрлөхд хамгаалагдсан зориулалтын хайрцааг савтай байх.

Стандарт

1. Монгол улсын болон олон улсын чанарын ISO9001:2000/SGS/SE стандартад нийцсэн байх
 2. Материал: Нүүрстөрөгчтэй ган
 3. Бариул: Резин эсвэл ПВХ материалаар бүрсэн,
 4. Стандарт хэмжил зүйн шалгалтаар орж тэнцсэн байх
 5. Ашиглалтын хугацаа: 5-10 жил
- 2. Стандарт:** ISO9001:2000/SGS/SE бусад холбогдох стандарт нормд нийцсэн.
- 3. Баглаа, боодол:** Бүтээгдхүүнийг тээвэрлэх, зөөвөрлөх үед гэмтээхгүй, чанар байдлыг алдагдуулахгүй байх.
- 4. Бараа хүргэх газар:** ОСНААУГ, Чингэлтэй дүүрэг, 6-р хороо, Бумцэндийн гудамж, Их тойруу Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар Төв агуулах

5. Бараа нийлүүлэлтийн хуваарь:

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
				Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгч ийн санал болгосон
1	3	4	5	6	7	8
Тусгай түлхүүр	ш	9	ОСЧААУГ-ын төв агуулах	Гэрээ байгуулснаас хойш 7 хоног	Гэрээ байгуулснаас хойш 14 хоног	
PVC шугамын хайч	ш	60	ОСЧААУГ-ын төв агуулах	Гэрээ байгуулснаас хойш 7 хоног	Гэрээ байгуулснаас хойш 14 хоног	
Гар трос	ш	19	ОСЧААУГ-ын төв агуулах	Гэрээ байгуулснаас хойш 7 хоног	Гэрээ байгуулснаас хойш 14 хоног	
Уртасгагч дамартай /50м/	ш	6	ОСЧААУГ-ын төв агуулах	Гэрээ байгуулснаас хойш 7 хоног	Гэрээ байгуулснаас хойш 14 хоног	
Гар таслагч /дунд/	ш	19	ОСЧААУГ-ын төв агуулах	Гэрээ байгуулснаас хойш 7 хоног	Гэрээ байгуулснаас хойш 14 хоног	
Цохилттой дрилл	ш	6	ОСЧААУГ-ын төв агуулах	Гэрээ байгуулснаас хойш 7 хоног	Гэрээ байгуулснаас хойш 14 хоног	
Цахилгаан клуп	ком	19	ОСЧААУГ-ын төв агуулах	Гэрээ байгуулснаас хойш 7 хоног	Гэрээ байгуулснаас хойш 14 хоног	
Наадаг багаж	ком	19	ОСЧААУГ-ын төв агуулах	Гэрээ байгуулснаас хойш 7 хоног	Гэрээ байгуулснаас хойш 14 хоног	
Түлхүүр /10-36/	ком	300	ОСЧААУГ-ын төв агуулах	Гэрээ байгуулснаас хойш 7 хоног	Гэрээ байгуулснаас хойш 14 хоног	
Төгсгөвч шахагч	ш	19	ОСЧААУГ-ын төв агуулах	Гэрээ байгуулснаас хойш 7 хоног	Гэрээ байгуулснаас хойш 14 хоног	
Кусачик	ш	97	ОСЧААУГ-ын төв агуулах	Гэрээ байгуулснаас хойш 7 хоног	Гэрээ байгуулснаас хойш 14 хоног	
Утас үзүүрлэгч	ш	97	ОСЧААУГ-ын төв агуулах	Гэрээ байгуулснаас хойш 7 хоног	Гэрээ байгуулснаас хойш 14 хоног	
Тестер	ш	97	ОСЧААУГ-ын төв агуулах	Гэрээ байгуулснаас хойш 7 хоног	Гэрээ байгуулснаас хойш 14 хоног	
Амперклещ	ш	24	ОСЧААУГ-ын төв агуулах	Гэрээ байгуулснаас хойш 7 хоног	Гэрээ байгуулснаас хойш 14 хоног	
Индикатор	ш	120	ОСЧААУГ-ын төв агуулах	Гэрээ байгуулснаас хойш 7 хоног	Гэрээ байгуулснаас хойш 14 хоног	

Отвертка нэмэх /+/	ш	97	ОСЧААУГ-ын төв агуулах	Гэрээ байгуулснаас хойш 7 хоног	Гэрээ байгуулснаас хойш 14 хоног	
Отвертка хасах /-/	ш	97	ОСЧААУГ-ын төв агуулах	Гэрээ байгуулснаас хойш 7 хоног	Гэрээ байгуулснаас хойш 14 хоног	
Купцы	ш	97	ОСЧААУГ-ын төв агуулах	Гэрээ байгуулснаас хойш 7 хоног	Гэрээ байгуулснаас хойш 14 хоног	

Дөрөв. ЖИШИГ МАЯГТ

1. УНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

- Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт унийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [моо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
- Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
- Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойло лт	Барааны гарал ўсслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НОАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

- Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгднө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхгүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/фак с	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших	1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт	2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ.
3. Оюуны өмчийн эрх	3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.
4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх	4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томьёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.
5. Баталгаат т засварын хугацаа	5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа <i>[too]</i> жил байна.
6. Гэрээнд өөрчлөлт оруулах	6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.
7. Төлбөр	7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш <i>[ГТН-д заасан too]</i> хоногийн дотор шуурхай хийнэ.
8. Бараа нийлүүлэх хуваарь	8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.
9. Алданги оногдуулах	9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.
10. Үүргээ	биелүүлээгүй эсэг гэрээг цуцлах

- 10.1. Нийлүүлэгч гэрээнд нийт үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.
- 11. Маргааныг шийдвэрлэх**
- 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- | | |
|--|--|
| 1. Шалгах болон турших (ГЕН – 1) | 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.] |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) | 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд: <ol style="list-style-type: none">1) нийлүүлэгчийн барааны нэр, too ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;5) барааны гарал үүслийн гэрчилгээ. |
| Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна. | |
| 3. Баталгаа т засвар (ГЕН-5) | 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
[Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.] |
| 4. Төлбөр (ГЕН – 7) | 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:

Барааг бүрэн нийлүүлснээс хойш 30 хоногийн дотор нэхэмжлэх болон гэрээ дүгнэсэн протокол, тооцоо нийлсэн дүн, баримтыг үндэслэн төлнө. |
| 5. Алданги оногдуулах 0,5%- (ГЕН - 9)⁴ | 9.1. Алданги оногдуулах хувь: <i>Гэрээний үнийн дүнгийн хоногийн иас хэтрэхгүй</i>

Алдангийн нийт дүн: Гэрээний үнийн дүнгийн 10%-иас хэтрэхгүй |

Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ⁵

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № *[Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]*

..... хот/аймаг

Нэг талаас *[захиалагчийн нэр]* (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас *[нийлүүлэгчийн нэр]* (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож

_____ оны _____ сарын _____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь *[гэрээний нэр, дугаар]-г* (цаашид “бараа” гэх) *[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]* (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны _____ дугаар сарын _____ -аас _____ оны дугаар сарын _____ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг⁶;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний өрөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн
хуваарь; Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзод нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ
ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг] [Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]